



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/49/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-
Amgalanm@audit.gov.mn

Утас: 70453799, Цахим хаяг:
Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА М.ГАЛСҮРЭН
ТАНАА

2023 о.д. 10 № УВА-2023/49/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4, 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг үндэслэн Татварын Ерөнхий газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/56 дугаар тушаалаар “Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар хэлтсийн орон тоог шинэчлэн баталсан байна.

Аудитын гол асуудал

Татварын хэлтэс нь тайлант хугацаанд төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 198 тоот тогтоолоор 2,043,923.6 мянган төгрөгийн балансын үнэтэй конторын барилга хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

9239200088

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Залруулсан алдаа.....	15
5.4 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын зүйл	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,255,683.62	124,558,179.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,678.00	1,678.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,678.00	1,678.00
31110	Төгрөг	1,678.00	1,678.00
33	АВЛАГА	298,439.33	4,063,156.00
335	Бусад авлага	298,439.33	4,063,156.00
3351	Байгууллагаас авах авлага	298,439.33	4,063,156.00
35	БАРАА МАТЕРИАЛ	108,955,566.29	120,493,345.67
354	Хангамжийн материал	108,955,566.29	120,493,345.67
35410	Бичиг хэргийн материал	26,383,472.50	25,015,872.50
35420	Аж ахуйн материал	6,420,600.00	19,202,579.38
35430	Сэлбэг хэрэгсэл	799,800.00	719,800.00
35450	Барилгын засварын материал	0.00	203,400.00
35470	Бусад хангамжийн материал	75,351,693.79	75,351,693.79
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	455,542,645.78	2,354,464,531.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	455,542,645.78	2,354,464,531.08
392	Биет хөрөнгө	412,976,645.78	2,334,464,531.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	117,216,941.53	2,043,923,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33,173,432.08	-8,393,936.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,990,000.00	98,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-59,471,279.40	-75,955,318.15
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	246,394,650.61	253,251,463.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-32,621,511.06	-42,263,337.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,772,676.50	90,772,676.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,008,331.42	-32,176,473.06
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,671,400.00	8,671,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,794,468.90	-2,355,544.00
393	Биет бус хөрөнгө	42,566,000.00	20,000,000.00
39301	Програм хангамж	480,000.00	480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-480,000.00	-480,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	42,566,000.00	20,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	564,798,329.40	2,479,022,710.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	564,798,329.40	2,479,022,710.75
51	Засгийн газрын хувь оролцоо	564,798,329.40	2,479,022,710.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,245,746.77	249,245,746.77
51101	Өмч: - төрийн	249,245,746.77	249,245,746.77
512	Хуримтлагдсан үр дүн	223,363,835.66	2,137,588,217.01
51210	Өмнөх үеийн үр дүн	200,288,215.97	223,363,835.66
51220	Тайлант үеийн үр дүн	23,075,619.69	1,914,224,381.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,188,746.97	92,188,746.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	564,798,329.40	2,479,022,710.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,151,657,240.99	3,034,082,892.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,309,429.99	2,060,020,092.14
120	Нийтлэг татварын бус орлого	65,309,429.99	2,060,020,092.14
120009	Бусад орлого	0.00	24,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		2,050,780,412.76
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	65,309,429.99	9,215,679.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,086,347,811.00	974,062,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,086,347,811.00	970,182,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,086,347,811.00	970,182,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	3,880,000.00
131103	ЗДНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	3,880,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,129,196,736.30	1,021,512,091.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,129,196,736.30	1,021,512,091.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,040,733,167.31	1,018,923,535.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,690,843.92	697,387,534.98
210101	Үндсэн цалин	418,767,510.62	456,031,020.32
210102	Нэмэгдэл	145,013,860.29	94,361,640.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,518,550.91	59,858,540.70
210104	Урамшуулал	112,390,922.10	87,136,333.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,305,860.67	88,087,039.33
210201	Тэтгэврийн даатгал	83,149,751.47	70,962,192.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,373,343.45	4,453,395.32
210203	ҮОМШ өвчний даатгал	3,407,954.75	3,508,956.22
210204	Ажилгүйдлийн даатгал	761,346.54	832,954.20
210205	Эрүүл мэндийн даатгал	7,613,464.46	8,329,541.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,619,021.55	56,711,468.80
210301	Гэрэл цахилгаан	3,623,617.55	7,936,337.90
210302	Түлш, халаалт	33,728,404.00	44,854,248.90
210303	Цэвэр, бохир ус	2,267,000.00	3,920,882.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,189,500.00	36,355,800.00
210401	Бичиг хэрэг	7,041,339.22	10,135,710.48
210402	Тээвэр, шатахуун	6,911,100.00	13,172,040.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,697,910.78	4,003,549.52
210404	Ном, хэвлэл	333,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,071,000.00	1,784,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,134,350.00	7,260,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,800,000.00	5,245,300.00
210604	Урсгал засвар	5,800,000.00	5,245,300.00
2107	Томилголт, зочны зардал	6,512,000.00	2,504,300.00
210702	Дотоод албан томилголт	6,512,000.00	2,504,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,631,988.54	79,119,983.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,458,405.54	77,924,400.75
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,208.00	123,208.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	0.00

210807	Газрын төлбөр	425,600.00	425,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,983,952.63	53,512,108.30
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	8,552,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	50,431,952.63	53,512,108.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,463,568.99	2,588,556.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,732,510.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,732,510.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,731,058.99	2,588,556.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,731,058.99	2,588,556.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	22,460,504.69	2,012,570,800.51
22	Үйл ажиллагааны бус зардлын дүн	0.00	98,346,419.16
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалсны гарз	0.00	98,346,419.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	22,460,504.69	1,914,224,381.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн /төгрөгөөр/
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,086,962,926.00	974,086,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	615,115.00	24,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	615,115.00	24,000.00
120009	Бусад орлого	615,115.00	24,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,086,347,811.00	974,062,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,086,347,811.00	970,182,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,086,347,811.00	970,182,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	3,880,000.00
131103	ЗДНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	3,880,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,086,962,926.00	974,086,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,086,962,926.00	974,086,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	998,499,357.01	971,498,243.53
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	733,705,146.92	701,450,690.98
210101	Үндсэн цалин	417,781,813.62	443,070,485.36
210102	Нэмэгдэл	145,013,860.29	99,558,894.90
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	58,518,550.91	60,554,922.43
210104	Урамшуулал	112,390,922.10	98,266,388.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,604,300.00	87,788,600.00
210201	Тэтгэврийн даатгал	83,448,190.80	70,663,752.87
210202	Тэтгэмжийн даатгал	4,373,343.45	4,453,395.32
210203	ҮОМШО-ний даатгал	3,407,954.75	3,508,956.22
210204	Ажилгүйдлийн даатгал	761,346.54	832,954.20
210205	Эрүүл мэндийн даатгал	7,613,464.46	8,329,541.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,619,021.55	56,711,468.80
210301	Гэрэл, цахилгаан	3,623,617.55	7,936,337.90
210302	Түлш, халаалт	33,728,404.00	44,854,248.90
210303	Цэвэр, бохир ус	2,267,000.00	3,920,882.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,226,900.00	35,103,000.00
210401	Бичиг хэрэг	7,057,639.22	8,768,110.48
210402	Тээвэр, шатахуун	6,911,100.00	13,172,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,697,910.78	4,003,549.52
210404	Ном, хэвлэл	333,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,071,000.00	1,784,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,155,450.00	7,375,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,800,000.00	5,352,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	0.00

210604	Урсгал засвар	800,000.00	5,352,700.00
2107	Томиллолт, зочны зардал	6,512,000.00	2,504,300.00
210702	Дотоод албан томиллолт	6,512,000.00	2,504,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,431,988.54	79,119,983.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,258,405.54	77,924,400.75
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	123,208.00	123,208.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	0.00
210807	Газрын төлбөр	425,600.00	425,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,600,000.00	3,467,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,600,000.00	3,467,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,463,568.99	2,588,556.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,732,510.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,732,510.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,731,058.99	2,588,556.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,731,058.99	2,523,556.47
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэг шилжүүлэг		65,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,678.00	1,678.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,678.00	1,678.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	200,923,215.35	542,357,709.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	200,923,215.35	542,357,709.09
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	23,075,619.69	23,075,619.69
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	223,363,835.66	564,798,329.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	223,363,835.66	564,798,329.40
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,914,224,381.35	1,914,224,381.35
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	249,245,746.77	92,188,746.97	2,137,588,217.01	2,479,022,710.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	1,678.00	-1,678.00	0.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		970,182,800.00	967,683,243.53	2,499,556.47	99.74
УРСГАЛ ЗАРДАЛ		970,182,800.00	967,683,243.53	2,499,556.47	99.74
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		970,182,800.00	967,683,243.53	2,499,556.47	99.74
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		702,308,300.00	701,450,690.98	857,609.02	99.88
Үндсэн цалин	21010100	417,610,200.00	443,070,485.36	-25,460,285.36	106.10
Нэмэгдэл	21010200	130,903,400.00	99,558,894.90	31,344,505.10	76.06
Унаа хоолны Хөнгөлөлт	21010300	66,792,000.00	60,554,922.43	6,237,077.57	90.66
Урамшуулал	21010400	87,002,700.00	98,266,388.29	-11,263,688.29	112.95
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		87,788,600.00	87,788,600.00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	21020100	59,696,200.00	70,663,752.87	-10,967,552.87	118.37
Тэтгэмжийн даатгал	21020200	7,023,100.00	4,453,395.32	2,569,704.68	63.41
ҮОМШӨ-ний даатгал	21020300	5,618,500.00	3,508,956.22	2,109,543.78	62.45
Ажилгүйдлийн даатгал	21020400	1,404,600.00	832,954.20	571,645.80	59.30
Эрүүл мэндийн даатгал	21020500	14,046,200.00	8,329,541.39	5,716,658.61	59.30
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		56,854,500.00	56,711,468.80	143,031.20	99.75
Гэрэл, цахилгаан	21030100	6,600,000.00	7,936,337.90	-1,336,337.90	120.25
Түлш, халаалт	21030200	44,854,500.00	44,854,248.90	251.10	100.00
Цэвэр, бохир ус	21030300	5,400,000.00	3,920,882.00	1,479,118.00	72.61
Хангамж, бараа материалын зардал		31,538,000.00	31,538,000.00	0.00	100.00
Бичиг хэрэг	21040100	8,155,900.00	7,513,110.48	642,789.52	92.12
Тээвэр, шатахуун	21040200	11,174,000.00	13,172,040.00	-1,998,040.00	117.88
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21040300	6,260,800.00	4,003,549.52	2,257,250.48	63.95
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21040500	539,300.00	1,784,000.00	-1,244,700.00	330.80
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21040600	5,408,000.00	5,065,300.00	342,700.00	93.66
Эд хогшил, урсгал засварын зардал		5,352,700.00	5,352,700.00	0.00	100.00
Урсгал засвар	21060400	5,352,700.00	5,352,700.00	0.00	100.00
Томиллолт, зочны зардал		2,504,300.00	2,504,300.00	0.00	100.00
Дотоод албан томиллолт	21070200	2,504,300.00	2,504,300.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		80,368,900.00	78,869,983.75	1,498,916.25	98.13
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21080100	79,173,200.00	77,674,400.75	1,498,799.25	98.11
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21080200	432,000.00	432,000.00	0.00	100.00
Даатгалын үйлчилгээ	21080300	170,800.00	170,775.00	25.00	99.99
Тээврийн хэрэгслийн татвар	21080500	123,300.00	123,208.00	92.00	99.93
Тээврийн хэрэгслийн оношилгоо	21080400	44,000.00	44,000.00	0.00	100.00
Газрын төлбөр	21080700	425,600.00	425,600.00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал		3,467,500.00	3,467,500.00	0.00	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	21090200	3,467,500.00	3,467,500.00	0.00	100.00

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		0.00	970,182,800.00	970,182,800.00	0.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		0.00	970,182,800.00	970,182,800.00	0.00
Улсын төсвөөс санхүүжих	13100100	0.00	970,182,800.00	970,182,800.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	1,678.00	-1,678.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	1,678.00	-1,678.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,880,000	0.00	100.00
УРСГАЛ ЗАРДАЛ		3,880,000	0.00	100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,815,000	0.00	100.00
Хангамж, бараа материалын зардал		3,565,000	0.00	100.00
Бичиг хэрэг		970,000	0.00	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,595,000	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		250,000	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		250,000	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		65,000	0.00	100.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		65,000	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,880,000	0.00	100.00
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,880,000	0.00	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Татварын хэлтэс нь эрхэм зорилгын хүрээнд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Татварын ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/56 тоот тушаалаар Увс аймгийн Татварын хэлтсийг 47 орон тоотой байхаар баталсан байна.

Татварын хэлтэс нь захиргаа хуулийн тасаг, жижиг татвар төлөгчтэй харилцах тасаг, бичил татвар төлөгчтэй харилцах тасаг, хяналт шалгалтын тасаг гэсэн 4 тасагтайгаар 47 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2022 онд тус хэлтэс нь татварын орлогыг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж улсын төсөвт 4,971,412.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,161,262.1 мянган төгрөг төвлөрүүлж

83.7%, аймгийн төсөвт 1,410,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,486,640.7 мянган төгрөг төвлөрүүлж 105.4%, сумын төсөвт 13,413,055.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 14,057,673.2 мянган төгрөг төвлөрүүлж 104.8%, нийт дүнгээр төлөвлөгөөний биелэлт 99.5 %-иар давуулан биелүүлсэн байна. Сумын төсвийн төлөвлөгөө тасарч байгаа нь мөнгөн хадгаламжийн хүү, хадгаламж эзэмшигчийн тоо буурсан, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 2021 оны гүйцэтгэлээр төлөвлөгөөг төлөвлөсөнтэй холбоотой тасарч байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь татварын ерөнхий хууль, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, хувь хүний орлогын албан татварын тухай, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, онцгой албан татварын тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд аж, ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2 удаагийн, хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орсныг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Татварын ерөнхий газрын дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас тус онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Увс аймгийн Татварын хэлтсийн даргын 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/30 дугаар тушаалаар тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, дутагдсан хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Татварын хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,910.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.6	1.6	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	108,955.5	120,493.3	11,537.8
Үндсэн хөрөнгө	455,542.6	2,354,464.5	1,898,921.9
Нийт хөрөнгө	564,798.3	2,474,959.5	1,910,161.2
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	564,798.3	2,474,959.5	1,910,161.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	564,798.3	2,474,959.5	1,910,161.2

Бараа материалын дансны үлдэгдэл 120,493.3 мянган төгрөг болж 11,537.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал худалдан авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,354,464.5 мянган төгрөг болж 1,898,921.9 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь конторын барилга дансанд бүртгэж авсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 951.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 18.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 970.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 18.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 970.1 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 970.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 967.6 сая төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 2.6 сая төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Татвар хураалт орлого бүрдүүлэлт / үндсэн үйл ажиллагаа 70205/80101	892,209.6	891,208.7	1,000.9	99.9
2	Татвар хураалт орлого бүрдүүлэлт / холбоо суваг ашигласны хөлс 70205/80220	53,673.2	53,673.2	0	100
3	Татвар хураалт орлого бүрдүүлэлт / харуул, хамгаалалтын зардал 70205/80219	24,300.0	22,801.3	1,498.7	96.7
ДҮН		970,182.8	967,683.2	2,499.6	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын захирамж А/254 тоот тушаалаар эрх шилжүүлж засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтээс 3.8 сая төгрөг орж ирснийг татвар төлөгчдийн өдөрт зориулан зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ч.Мөнхтогтох 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 02 дугаар сарын 07-ны өдрийн хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 11.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,119.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 11.1 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 8.9 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Увс аймгийн Татварын хэлтэс нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал гараагүй байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 2.5 сая төгрөгийн томилолтын зардлыг газрын дарга Улаанбаатар хотод удирдах ажилтны зөвлөгөөнд оролцох, сумдаар хяналт шалгалтаар ажилласан албан хаагчид олгосон байна.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн хувьд энэ онд тэтгэвэрт гарсан албан хаагч байхгүй байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн хувьд холбоотой зардал гараагүй байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149, мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Татварын хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд алдаа зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нэмэгдсэн хөрөнгийн элэгдэл тооцсон эсэхийг анхаарч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 8.4 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 198 дугаар тогтоолоор 2,043,923.6 мянган төгрөгийн балансын үнэтэй конторын барилга хүлээн авч данс бүртгэлд тусгасан хэдий ч тухайн барилга байгууламжид элэгдлийн зардал тооцоогүй байна. Энэ нь УСНББОУС-17, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 1-р хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.40 дэх заалтыг зөрчсөн байна.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар 2,043,923.6 мянган төгрөгийн балансын үнэтэй конторын барилга хүлээн авч данс бүртгэлд тусгасан хэдий ч тухайн барилга байгууламжид элэгдлийн зардал тооцоогүй байсныг аудитын явцад нөхөн тооцуулж 8,393.9 мянган төгрөгийн алдааг залруулсан болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.4 Зөвлөмж

1. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1.1. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтад “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчин цалингийн зардлаас хувь хүний орлогын албан татварын ашигт 4,063.1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгийн элэгдэл тооцож бүртгэсэн	2	12,457.1	1	8,393.9			1	8,393.9			1	4,063.1
Дүн	2	12,457.1	1	8,393.9			1	8,393.9			1	4,063.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Илүү шилжүүлсэн хаоат	1	4,063.1	0	0	0	0	1	4,063.1	0	0	0	0
Дүн	1	4,063.1	0	0	0	0	1	4,063.1	0	0	0	0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Ч.МӨНХТОГТОХ/

2023 оны 02 сарын 09-ны өдөр